



BOGD BANK
JOINT STOCK COMPANY

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН МАТЕРИАЛ

IKH BOGD MOUNTAIN

3957m

Mongolia, Bayankhongor



www.bogdbank.com



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Огноо: 2024.12.16

№ 24/146

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3, 76 дугаар зүйлийн 76.1.2, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 60 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.4, 62.1.15, 62.1.16, 65 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн №377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12-р сарын 16-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Богд банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал /цаашид “Хурал” гэх/-ыг 2025 оны 02-р сарын 03-ны өдөр 11:00 цагт “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшныг ашиглан цахимаар хуралдуулсугай.
2. Ээлжит бус хурал зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 12-р сарын 19-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Саруул/-д даалгасугай.
3. Ээлжит бус хурал хуралдуулах тухай зар мэдээг компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёр сонин эсвэл телевизийн 2 сувгаар дамжуулан 2024 оны 12-р сарын 20-ны өдөр, 2025 оны 01-р сарын 04-ний өдөр тус тус мэдээлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 01-р сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 5.1. “Богд банк” нээлттэй ХК-ийн хэлбэрийг өөрчилж хаалттай ХК болох;
 - 5.2. Компанийн хэлбэрийг өөрчлөхтэй холбоотойгоор Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
6. Ээлжит бус хурлын хэлэлцэх асуудлаар гаргах хурлын шийдвэрийн төсөл, тэдгээрийн танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигч нарт хүргэх хурлын материалыг 2024 оны 12-р сарын 25-ны өдөрт багтаан бэлтгэж үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлж хувьцаа эзэмшигчдээс хурлын материалтай ажлын өдрийн 10:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломж бүрдүүлж ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга: Б.Онон

Комиссын гишүүн: Ж.Ууганчулуун

Комиссын гишүүн: Э.Пүрэвжаргал

8. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
Хурал зохион байгуулах комиссын дарга: Б.Уламбаяр /Богд банк ХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал/
Гишүүд: Б.Нармандах /Хуулийн хэлтсийн захирал/
Гишүүд: Б.Урангоо /Хуульч/
Гишүүд: М.Дэлгэрмөрөн /ТУЗ-н нарийн бичиг/
Гишүүд: М.Хүдэрчулуун /Маркетингийн хэлтсийн захирал/
9. “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зар”-ыг нэгдүгээр, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэг”-ийг хоёрдугаар, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотойгоор “Хувьцаа эзэмшигчид танилцуулах баримт бичгийн жагсаалт”-ыг гуравдугаар, хувьцаа эзэмшигчдээс санал авах “Саналын хуудас”-ыг дөрөвдүгээр, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарах шийдвэрийн төслүүдийг саналын хуудасны хавсралтаар тус тус баталсугай.
10. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчийг саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж “БиДиСек ҮЦК” ХК-ийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, Төв байр хаягаар, Богд банк ХК-ийн Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 3, Бодь цамхаг, 4 дүгээр давхар хаягаар тус тус дамжуулан авах ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2025 оны 01-р сарын 27-ны өдрийн 17:00 цаг байхаар тогтоосугай.
11. Хурлын даргаар “Богд банк” ХК-ийн ТУЗ-ийн дарга /Л.Болдхуяг/-ыг томилсугай.
12. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу 2025 оны 02-р сарын 06-ны өдрийн дотор Монголын Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Уламбаяр/-т үүрэг болгосугай.
13. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох мэдээлэл, баримт бичгийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Дотоод аудитын газар /Д.Төрмандах/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

“Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
№ 146 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



**“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАР**

Компанийн нэр: “Богд Банк” ХК

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бодь цамхаг

Хурал хуралдах огноо, цаг, газар: 2025 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 11:00 цагт болно.

Хурал зохион байгуулах хэлбэр: “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшныг ашиглан цахимаар хуралдана.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2025 оны 01-р сарын 08-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал:

1. “Богд банк” нээлттэй ХК-ийн хэлбэрийг өөрчилж хаалттай ХК болох;
2. Компанийн хэлбэрийг өөрчлөхтэй холбоотойгоор Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:

- Ээлжит бус хурлын хэлэлцэх асуудлаар гаргах хурлын шийдвэрийн төсөл, тэдгээрийн танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигч нарт хүргэх хурлын материалыг 2024 оны 12-р сарын 25-ны өдөрт багтаан бэлтгэж үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлнэ.
- Та тус Үнэт цаасны компанитай холбогдон хурлын материалаа авахыг хүсье.

Хувьцаа эзэмшигч та 2025 оны 01-р сарын 27-ны өдрийн 17:00 цагаас өмнө ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд өөрт тохиромжтой дараах газруудын аль нэгт эсхүл <https://www.bogdbank.com/> цахим хуудсаар хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв байр, Хаяг: Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
- “Богд Банк” ХК-ийн төв байр буюу Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Жигжиджавын гудамж 3, Бодь цамхаг, 4 дүгээр давхарт ирж хурал зохион байгуулах комиссын гишүүн Б.Урангоо /Утас: 8090-8491/ мэдэгдэн хурлын баримт бичигтэй танилцах боломжтой.

Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилан өгөх боломжоор хангаж “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв байр, Хаяг: Залуучуудын өргөн чөлөө 27/1, 8-р хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот хаягаар, Богд банк ХК-ийн Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 3, Бодь цамхаг, 4 дүгээр давхар хаягаар тус тус дамжуулан авах ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2025 оны 01-р сарын 27-ны өдрийн 17:00 цаг байна. Холбоо барих: 75771199, 8090-8491,

И-мэйл хаяг: info@bogdbank.com, broker@bdsec.mn

Хурал зохион байгуулах комисс-той доорхи хаягаар холбоо барина уу:

Гишүүн: Б.Урангоо
Email: urangoo.b@bogdbank.com
Утас: 8090-8491

“Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
№44/146 тоот тогтоолын хоёрдугаар дугаар хавсралт

**“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
БУС ХУРЛЫН ДЭГ**



Хурал 2025 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 11:00 цагт “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшныг ашиглан цахимаар эхэлнэ.

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцан танилцуулагч
1	Хурал болох өдрөөс өмнө саналаа ирүүлсэн Хувьцаа эзэмшигчид болон хуралд оролцож буй Хувьцаа эзэмшигчдийг бүртгэж хурлын ирцийн талаар тооллогын комиссын шийдвэр гаргаж хурлын дарга болон хуралд оролцож буй Хувьцаа эзэмшигч нарт танилцуулах	11:00-11:10	Тооллогын комисс
2	Хурлын дарга хурлыг нээж хурлын дэгийг танилцуулах	11:10-11:15	Хурлын дарга
3	Хэлэлцэх асуудлын дагуу дараах асуудлуудыг хэлэлцүүлнэ. Үүнд: 1.1. “Богд банк” нээлттэй ХК-ийн хэлбэрийг өөрчилж хаалттай ХК болох; 1.2. Компанийн хэлбэрийг өөрчлөхтэй холбоотойгоор Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;	11:15-12:20	Гүйцэтгэх захирал
5	Хэлэлцэж буй асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	12:20-12:30	Хуралд оролцогсод
6	Хурлаас гарах шийдвэрийн төсөл бүрийг танилцуулах	12:30-12:35	Хурлын дарга
7	Хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариулт	12:35-12:40	Хуралд оролцогсод
8	Хуралд оролцож буй Хувьцаа эзэмшигчид болон Хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн оролцогчдоос хурлаас гарах шийдвэрт өгөх саналаа тусгасан саналын хуудсыг хүлээн авах	12:40-13:00	Тооллогын комисс
9	Завсарлага	13:00-13:10	Хурал зохион байгуулах комисс
10	Хуралд биечлэн оролцож буй Хувьцаа эзэмшигчид болон Хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн оролцогчдоос хурлаас гарах шийдвэрт өгөх саналыг хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэх	13:10-13:30	Тооллогын комисс
11	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд саналын хуудсаар саналаа ирүүлсэн Хувьцаа эзэмшигчдийн саналыг тоолж хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэх	13:30-14:00	Тооллогын комисс

12	Хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэсэн Хувьцаа эзэмшигчдийн саналын дүнг тооллогын комиссын тогтоол болгон гаргах.	14:00-14:10	Тооллогын комисс
13	Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн хурлаас гарах тогтоолыг боловсруулах	14:10-14:20	Тооллогын комисс
14	Хурлаас гарах шийдвэр бүрээр нэгтгэсэн Хувьцаа эзэмшигчдийн саналын дүнгээр гарсан тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	14:20-14:25	Тооллогын комисс
15	Хурлаас гарах шийдвэрийг танилцуулах	14:25-14:30	Хурлын дарга
16	Хурлыг хаах	14:30	Хурлын дарга

—000—

*“Богд банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
№24/146 тоот тогтоолын гуравдугаар хавсралт*



**“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД
ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн №24/146 тоот тогтоол;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
4. Компанийг хэлбэрийг өөрчлөхтэй холбоотой танилцуулга;
5. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрийн төслүүд;
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлаар гаргах шийдвэрийн төсөлд ХЭ-ээс санал өгөх саналын хуудас.

Компанийн тухай хуулийн 65.6-д заасан заалттай холбогдуулан хувьцаа эзэмшигч та бүхэнд танилцуулах зорилгоор дараах зүйлсийг компанийн вэб хуудас болох <https://www.bogdbank.com/> хаягт байршуулсан тул та бүхнийг эдгээр материалтай танилцахыг хүсч байна. Үүнд:

1. Компанийн 2023 оны жилийн санхүүгийн тайлан, 2024 оны 1, 2, 3 дугаар улирлын тайлан;
2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн талаарх хараат бус аудитын байгууллагын дүгнэлт;
3. Компанийн 2023 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан;
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн товч танилцуулга;
5. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, тэдгээрийн эзэмшлийн хувьцааны төрөл, тоо;
6. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсөв;

Дээр дурдсан баримт бичиг нь 2024 оны 12-р сарын 25-ны өдрийн дотор бэлэн болсон байна.

oooOooo

“Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
№ 4/14 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралт

**“БОГД БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛД ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС**

1. Хувьцаа эзэмшигчийн нэр:
2. Регистрийн дугаар:
3. Эзэмшиж байгаа хувьцааны төрөл: Энгийн
4. Эзэмшиж буй хувьцааны тоо: ширхэг
5. Үнэт цаасны компани дахь бүртгэлийн дугаар:
6. Бүртгэсэн ҮЦК-ийн нэр:
7. Брокерын овог нэр:

№	Хэлэлцэж, батлах асуудлууд	Тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Түдгэлзсэн	Татгалзсан	Татгалзсан бол таны өгөх санал
1	“Богд банк” нээлттэй ХК-ийн хэлбэрийг өөрчилж хаалттай ХК болох	Хурлын материалд байгаа ХЭ-ийн ээлжит бус хурлаас гарах нэгдүгээр дүгээр шийдвэрийн төсөл				
2	Компанийн хэлбэрийг өөрчлөхтэй холбоотойгоор Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах	Хурлын материалд байгаа ХЭ-ийн ээлжит бус хурлаас гарах хоёр дугаар шийдвэрийн төсөл				

Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг	
Хувьцаа эзэмшигч хувь хүний бөглөх хэсэг	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн бөглөх хэсэг
Хувьцаа эзэмшигч иргэний овог, нэр	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нэр
Гарын үсэг.....	Улсын бүртгэлийн дугаар.....
Хэрэв иргэн та саналаа итгэмжлэгдсэн этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр: Регистрийн дугаар:	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр: Албан тушаал:..... Гарын үсэг:

Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг:
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг:.....

Тооллогын комиссын бөглөх хэсэг:	
Саналын хуудсыг хүчинтэй/хүчингүйд (доогуур зурах) тооцон тоолсон	
Тооллогын комиссын Дарга:	
Гишүүн:	
Гишүүн:	
Гишүүн:	
Гишүүн:	
Хүчингүйд тооцсон бол шалтгаан	
.....	
.....	

Хувьцаа эзэмшигч та танд илгээсэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай мэдэгдэлд заасан хурлаас гарах шийдвэрийн төсөл болон түүнтэй холбоотой бусад материалтай 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 17 цагаас өмнө танилцан энэхүү саналын хуудсыг доор заасны дагуу бөглөн ирүүлнэ үү.

Саналын хуудсыг бөглөх санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгт (+) эсхүл (☒) гэсэн тэмдэглэгээг хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+) эсхүл (☒) , түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд (+) эсхүл (☒) , татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд (+) эсхүл (☒) тэмдэг тавина.
2. Хэрэв татгалзсан бол та тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөлд өгөх өөрийн саналаа татгалзсан бол таны өгөх санал гэсэн багананд бичнэ үү
3. Засварласан, балласан, залруулгатай эсхүл давхар тэмдэглэгээний аль нэгийг хийсэн бол санал авах хуудас нь **хүчингүйд** тооцогдоно.
4. Хэрэв та *Саналын хуудаст* энэхүү санамжийн 1-т заасан тэмдэглэгээний аль нэгийг хийгээгүй бол Түдгэлзсэнд тооцно.
5. Хэрэв та *Саналын хуудсыг* буруу бөглөсөн бол Санал өгөгч нь Тооллогын комисс нэгтгэсэн дүнг гаргахаас өмнө *Саналын хуудсыг* дахин авч бөглөж болно.
6. Хэрэв та хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол энэхүү санал авах хуудсанд саналаа тэмдэглэн, үйлчлүүлдэг үнэт цаасны компаниараа дамжуулан манайд илгээнэ үү.

Хурал : 2025 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 11:00 цагт “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн AGM веб суурьтай аппликейшныг ашиглан цахимаар болно.

Саналын хуудасны Хавсралт №1

**“БОГД БАНК” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР**



Компанийн хэлбэрийг өөрчилж хаалттай хувьцаат компани болгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4, Богд банкны дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.7.4-д заасныг тус тус удирдлага болгон компанийн хэлбэрийг өөрчилж хаалттай хувьцаат компани болгох асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 2025 оны 02-р сарын 03-ны өдрийн №..... тоот шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ нь:**

1. “Богд банк” нээлттэй хувьцаат компанийн хэлбэрийг өөрчилж “Богд банк” хаалттай хувьцаат компани болгосугай.
2. Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу энэхүү шийдвэрийг компанийн хувьцаа эзэмшигч нарт мэдэгдэх, тухайн үйл ажиллагааг зохион байгуулах, Банкны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д заасны дагуу банкныг өөрчлөн байгуулах комисс, банкны бүртгэлд байгаа эд хөрөнгө, үнэт зүйлсийг нягтлан шалгах эрх бүхий хянан шалгах комисс, тэдгээрийн бүрэлдэхүүнийг томилох болон аудитыг сонгохыг Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирал /Г.Саруул/-д даалгасугай.
3. Банкны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-т заасны дагуу энэхүү шийдвэрийг бүрдүүлбэрийн хамт ажлын 3 хоногт багтаан Монголбанканд хүргүүлж холбогдох зөвшөөрлийг авах ажиллагааг хариуцаж гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирал /Г.Саруул/-д үүрэг болгосугай.
4. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.БОЛДХУЯГ

Саналын хуудасны Хавсралт №2

**“БОГД БАНК” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ШИЙДВЭР**



Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1, Богд банкны дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.7.1-д заасныг тус тус удирдлага болгон компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын 2025 оны 02-р сарын 03-ны өдрийн №... тоот шийдвэрийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас **ШИЙДВЭРЛЭХ нь:**

5. “Богд банк” хаалттай ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсугай.
6. Энэхүү шийдвэрийг компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын хамт Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, Улсын бүртгэлд тус тус хүргүүлж баталгаажуулах, компанийн гэрчилгээг шинэчилж гаргуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Саруул/-д үүрэг болгосугай.
7. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Л.БОЛДХУЯГ

“Богд Банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын
2025 оны 02-р сарын 03-ны өдрийн №..... тоот шийдвэрийн хавсралт

“БОГД БАНК” ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ДҮРЭМ

/шинэчилсэн найруулга/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 **БОГДБАНК** хувьцаат компани /хаалттай ХК/ /цаашид “Банк” болон “Компани” гэх/ нь бие даасан тайлан тэнцэлтэй, Монголбанкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдлэн, үүрэг хүлээх, ашгийн төлөө, банкны үйл ажиллагаа явуулдаг, хувьцаа нь хаалттай арилжаалагддаг хуулийн этгээд байна.
- 1.2 Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмээр Банкны үйл ажиллагааг зохицуулна.
- 1.3 Банкны оноосон албан ёсны нэрийг
-монголоор: “**БОГДБАНК**” ХК
-англиар: “**BOGDBANK**” Joint Stock Company гэнэ.
- 1.4 Банкны оршин байгаа газрын хаяг:
БОГДБАНК
Бодь цамхаг
Жигжиджавын гудамж-3
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо
Улаанбаатар 15160, Монгол Улс
Утас: (+976) 75771199
- 1.5 Банк нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд хаалттай ХК гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.
- 1.6 Банк нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ болон компанийн засаглалын шилдэг жишгийг удирдлага болгоно.
- 1.7 Банкны салбар, тооцооны төв, тооцооны касс, валютийн цэг, төлөөлөгчийн газар нь толгойлох банкны оноосон нэрийг хэрэглэх буюу тус бүрийн хаягтай байна.
- 1.8 Банк өөрийн тэмдэг, бэлгэдэл болон албан ёсны хаяг бүхий албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.
- 1.9 Банк нь өөрийн тэмдэгтэй байна. Банкны тэмдэг нь Банкны албан ёсны нэрийг монгол хэл дээр бүтнээр нь тусгана.
- 1.10 Банкны тэмдэг нь Банкны албан ёсны нэрийг гадаад хэл дээр агуулж болох бөгөөд эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр бараа, үйлчилгээний тэмдэг, бэлгэдэл, лого болон бусад зүйлийг дүрсэлж болно.
- 1.11 Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, цуцалсан бөгөөд Банкны тухай хуульд заасны дагуу банкны эрх хүлээн авагч томилогдсон, хувьцаа эзэмшигчдийн хурлаас банкныг өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэсэн, шүүх дампуурлыг зарласнаас банк үйл ажиллагаагаа цаашид явуулах үндэслэлгүй болсноос бусад тохиолдолд Банкны үйл ажиллагаа хугацаагүй үргэлжилнэ.
- 1.12 Банкныг энэхүү дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөх болон өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгана.

ХОЁР. БАНКНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

- 2.1 Банк нь өөрийн тусгаарласан хөрөнгөтэй байх ба бие даан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдэлнэ. Банк нь бие даасан баланс, өөрийн нэр бүхий тэмдэг, логотой байх ба Банк нь төгрөгийн, гадаад валютын болон бусад данстай байна. Банк нь шүүх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, болон гуравдагч этгээдээр оролцох эрхтэй.
- 2.2 Банк нь өөрийн материаллаг болон мөнгөн хөрөнгөтэй байх ба тэдгээрийг ашиглах, захиран зарцуулах болон бусад эрхийг эдэлнэ.
- 2.3 Хувьцаа эзэмшигчид хувийн хөрөнгөөрөө Банкны өрийг хариуцахгүй ба Банк нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн өрийг хариуцахгүй. Харин Банкны хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр банкны алдагдал болон бусад хариуцлагыг хүлээнэ.
- 2.4 Банк нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг нээж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Банкнаас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.
- 2.5 Банк нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

ГУРАВ. БАНКНЫ ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 3.1 Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах нь Банкны үндсэн зорилго мөн.

- 3.2 Банкны эрхэм зорилго нь: Харилцагч бүрийнхээ амар тайвны төлөө ажиллаж, банкны хөгжлөөр дэлхийд өрсөлдөнө. Итгэл түгээнэ.
- 3.3 Банк нь хууль тогтоомж, бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон дараах үйл ажиллагаа, ажил үйлчилгээг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлнэ. Үүнд:
- 3.3.1 Зээлийн үйл ажиллагаа;
 - 3.3.2 Төлбөр тооцооны үйлчилгээ;
 - 3.3.3 Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
 - 3.3.4 Гадаад төлбөр тооцоо хийх;
 - 3.3.5 Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах үйл ажиллагаа;
 - 3.3.6 Мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа;
 - 3.3.7 Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;
 - 3.3.8 Зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах;
 - 3.3.9 Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа;
 - 3.3.10 Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа;
 - 3.3.11 Үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
- 3.4 Банк нь эрхлэх үйл ажиллагааныхаа хүрээнд дүрэм, заавар, журам боловсруулж зохих журмын дагуу батлаж мөрдөнө.
- 3.5 Монгол Улсын хууль тогтоомжоор тусгай зөвшөөрөл авахаар тусгайлан заасан үйл ажиллагааг эрхлэхдээ холбогдох тусгай зөвшөөрөл авч тухайн төрлийн үйл ажиллагааг эрхэлнэ.
- 3.6 Үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор хаалттай зах зээл дээр үйл ажиллагаа явуулна.

ДӨРӨВ. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

- 4.1 Банк нь хувьцаа эзэмшигчдээс оруулсан мөнгөн хөрөнгөөр бүрдүүлсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг гагцхүү мөнгөн хөрөнгөөр бүрдүүлнэ.
- 4.2 Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 80 төгрөгний нэрлэсэн үнэтэй 1,250,000,000 (нэг тэрбум хоёр зуун тавин сая) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөг байна. Банк хуульд заасан журмын дагуу хувьцааны хувь хэмжээ, үнэ, дүнг өөрчилж болно.
- 4.3 Банк нь шинээр нэмж зарласан хувьцаатай байна. Банк хуульд заасан журмын дагуу зарласан хувьцааны хэмжээ, үнэ, дүнг өөрчилж болно.
- 4.4 Хувь нийлүүлсэн хөрөнгө, түүний доод хэмжээг Монголбанкнаас тогтоох бөгөөд уг хэмжээг баримтална.
- 4.5 Банк хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон хувьцаанаас бусад аливаа үнэт цаасыг хуульд заасан журмаар гаргаж болно.
- 4.6 Банк гүйлгээнд гаргасан өөрийн хувьцааг хуульд заасан журмаар эргүүлэн худалдан авсан бол эдгээр хувьцааг халаасны хувьцаа гэж үзэх бөгөөд балансад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэсэгт нэрлэсэн үнээр нь хасах тэмдэгтэйгээр харуулна.
- 4.7 Банкны нийт биет болон биет бус хөрөнгийн дүнгээс Банкны нийт өр төлбөрийг хасаад үлдсэн дүнг өөрийн хөрөнгө гэх бөгөөд өөрийн хөрөнгийн дүн нь санхүүгийн тайлан баланс гарах бүрт өөрчлөгдөнө.
- 4.8 Зарласан хувьцааны хүрээнд шинээр хувьцаа гаргаж хөрөнгө оруулбал тэр хэмжээгээр Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө болон гаргасан хувьцааны тоо нэмэгдэнэ.
- 4.9 Алдагдал гарсан, үндсэн ба эргэлтийн хөрөнгийг устгасан, найдваргүй авлагыг данснаас хассан зэрэг тохиолдолд тэр хэмжээгээр Банкны хуримтлагдсан ашиг болон өөрийн хөрөнгө буурна. Хувьцааны тоо болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөхгүй.
- 4.10 Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг дахин үнэлж, үнэлгээний зөрүүг бүртгэлд тусгасан тохиолдолд өөрийн хөрөнгө ба хувьцааны балансын үнэ нэмэгдэж, хорогдоно.
- 4.11 Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааг захиран зарцуулах эрх нь энэ дүрмээр хязгаарлагдана. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа Монголбанкны зөвшөөрлийн дагуу бусдад худалдах, бэлэглэх, өв залгамжлуулах зэргээр бусдад шилжүүлж болно.
- 4.12 Хувьцаа эзэмшигч өөрийн хувь хөрөнгөө өв залгамжлуулах тохиолдолд Монгол Улсын Иргэний хуульд заасан журмыг баримтална.
- 4.13 Банк өөрийн гаргасан хувьцааг хуульд заасан журмаар эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр эргүүлэн худалдан авч болно. Банк энгийн хувьцааг тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй, бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь худалдан авч болно.
- 4.14 Банк дараах нөхцөлд өөрийн гаргасан үнэт цаасыг эргүүлэн авах шийдвэрийг гаргаж болно. Үүнд:
- 4.14.1 Эргүүлэн авах үүрэг бүхий хувьцааг эргүүлэн авсан
 - 4.14.2 Үнэт цаасаа эргүүлэн авсанаар төлбөрийн чадвартай байх
 - 4.14.3 Татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээ зэргийн нийлбэрээс илүү байх.
 - 4.14.4 Хуульд заасан бусад үндэслэл

4.15 Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн шийдвэрт үндэслэн, Монголбанкны зөвшөөрлийн дагуу дараах байдлаар өөрчилж болно. Үүнд:

- 4.15.1 Нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах;
- 4.15.2 Хувьцаа нэмж гаргах замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөх;
- 4.15.3 Өөрийн гаргасан хувьцааг худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах;
- 4.15.4 Хуульд заасан бусад үндэслэл

ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Банкны энгийн болон давуу эрхийн хувьцааг эзэмшиж байгаа этгээд Банкны хувьцаа эзэмшигч болно.
- 5.2 Энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрхтэй:
 - 5.2.1 эцнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” Банкны хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
 - 5.2.2 ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хувиарлаагүй бол алданги төлөхийг шаардах;
 - 5.2.3 Банкныг татан буулгах үед Банкны тухай хуульд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;
 - 5.2.4 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг хуульд заасан журмаар Банкинд эргүүлэн авахыг шаардах;
 - 5.2.4.1 нийлэх, нэгдэх, хуваах болон Банкны хэлбэрийг өөрчлөх;
 - 5.2.4.2 хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, Банкны урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;
 - 5.2.4.3 хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай Банкны дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;
 - 5.2.4.4 нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт Банкны энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон, эсхүл Банкны төрийн мэдлийн багц хувьцааг худалдсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь Банкинд хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй;
 - 5.2.5 Энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, Банкны ТУЗ-д болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисст нэр дэвшүүлэх;
 - 5.2.6 Банкны анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах;
 - 5.2.7 Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь Банкны аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд Аудитын шалгалт хийлгэх;
 - 5.2.8 Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувийг эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;
 - 5.2.9 Банкны эрх бүхий албан тушаалтан Банкны тухай хууль болон энэ дүрмийн 13.2-т заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс Банкинд хохирол учруулсан бол уг албан тушаалтнаар Банкинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
 - 5.2.10 Хувь нийлүүлсэн хөрөнгөө (хувьцааны төлбөр) зөвхөн мөнгөн хэлбэрээр оруулах;
 - 5.2.11 Банкны ашиг орлогыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн үр дүнтэй ашиглалтыг сайжруулах талаар санал, шүүмжлэл гаргах;
 - 5.2.12 Банкны Хувьцаа эзэмшигч оруулсан хөрөнгийн хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээж, алдагдлыг нөхнө;
 - 5.2.13 хууль тогтоомжинд заасан бусад эрх;
- 5.3 Банкны хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй:
 - 5.3.1 Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;
 - 5.3.2 Нийт гаргасан хувьцааны 1/3 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу Банкны хувьцааг худалдан авах санал гаргах;

5.3.3 Нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай Банкинд бичгээр мэдэгдэх;

5.3.4 хууль тогтоомжинд заасан бусад үүрэг;

5.4 Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.

5.5. Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль болон давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт заасан нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцоно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх, тэдний хувь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл зэргийг давуу эрхийн хувьцаа гаргах тухай асуудлыг шийдвэрлэсэн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрт заасан байна.

ЗУРГАА. БАНК ҮНЭТ ЦААС ГАРГАХ ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ

6.1 Банк хуульд заасны дагуу давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг гаргаж болно. Энэ тохиолдолд шаардлагатай бол холбогдох зөвшөөрлийг Монголбанк болон хууль, тогтоомжинд заасан бусад байгууллагаас авна.

6.2 Энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг нийтэд санал болгон гаргах эсхүл энгийн хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авч, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.

6.3 Банк нь хуульд заасны дагуу өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй үнийн дүн бүхий өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. ТУЗ-ийн шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.

6.4 Банк нь хуульд заасны дагуу тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах, худалдах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.

6.5 Хувьцаа бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу Банкны ТУЗ тогтоож болно.

6.6 Банкнаас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийн хэлбэрийг /мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө/ үнэт цаас гаргах тогтоол дээр тодорхой зааж өгнө. Мөнгөн бус хэлбэрээр гүйцэтгэх тохиолдолд үнэлгээг тогтоохдоо ТУЗ нь мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

6.7 Банк өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу брокерт захиалга өгөх замаар худалдан авч болно.

6.8 Банк өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдаж авахаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

6.9 Хэрэв үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий этгээдийн шийдвэрт заасан бол гаргасан үнэт цаасыг худалдан авч байгаа этгээд нь төлбөрөө мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн аль ч хэлбэрээр хийж болно.

6.10 Банк нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

ДОЛОО. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

7.1 Банкны эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлдэх, хурлын зар мэдээг хүргэх, хурал хуралдуулах, тэмдэглэл хөтлөх, шийдвэр болон хурлын тэмдэглэлийг баталгаажуулах, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх журам” болон Банкны холбогдох журмаар зохицуулна.

7.2 Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.

7.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор буюу 5 дугаар сарын 01-ний дотор ТУЗ зарлан хуралдуулна.

7.4 Хувьцаа эзэмшигчдийн хуралд Банкны нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 50 болон түүнээс дээш хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

7.5 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдан явуулна. ТУЗ-ийн дарга хуралд оролцох боломжгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай асуудлыг шийдвэрлэсэн ТУЗ-ийн хурлаас томилогдсон этгээд хурлыг удирдана. Хурал удирдахаар томилогдсон этгээд хуралд хүрэлцэн ирэх боломжгүй нь хурал хуралдах үед илэрхий болсон бол хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар хурал даргалагчийг сонгоно.

- 7.6 Шаардлагатай үед ТУЗ, эсхүл ТУЗ-ийн 2-оос доошгүй хараат бус гишүүн, саналын эрхийн 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн санаачилгаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ТУЗ-өөс зарлан хуралдуулах, ТУЗ энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй бол тухайн этгээд өөрөө хуулийн дагуу зарлан хуралдуулах эрхтэй.
- 7.7 Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 7.7.1 Банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;
 - 7.7.2 нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр Банкныг өөрчлөн байгуулах;
 - 7.7.3 Банкны өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;
 - 7.7.4 Банкны хэлбэрийг өөрчлөх
 - 7.7.5 Банкныг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 7.7.6 хувьцааг хуваах буюу нэгтгэх.
- 7.8 Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Үүнд:
- 7.8.1 ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;
 - 7.8.2 Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчдэд хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх;
 - 7.8.3 Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлэх;
 - 7.8.4 Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг хийх тухай шийдвэрийг ТУЗ санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхиор шийдвэрлэх;
 - 7.8.5 ТУЗ-с хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд энэ хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
 - 7.8.6 Банкны өөрийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахыг зөвшөөрөх;
 - 7.8.7 ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
 - 7.8.8 ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.
 - 7.8.9 Компаний хууль болон дүрэмд заасан бусад асуудал
- 7.9 Банкны нэг ширхэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.
- 7.10 ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүний тоогоор үржүүлж саналын эрхийн тоог тодорхойлно. ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшсэн хүмүүсийн нэрийг саналын хуудсанд оруулахдаа ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж хүмүүсийн нэрсийг тус тусад нь жагсаана.
- 7.11 Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгөх бөгөөд ТУЗ нь 9 гишүүнтэй байхаар дүрэмдээ заасан бол энгийн гишүүнд нэр дэвшиж буй 1-6 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 2/3-ийг, хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 1-3 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 1/3-ийг өгсөн байна. Энэ хуваарийг зөрчиж санал өгсөн бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- 7.12 Хэрэв кумулятив аргыг хэрэглэх, тооцох талаар Санхүүгийн зохицуулах хорооноос журамласан тохиолдолд түүнийг дагаж мөрдөнө.
- 7.13 Хувьцаа эзэмшигч өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болох бөгөөд уг этгээд нь энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.
- 7.14 Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.
- 7.15 Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ.
- 7.16 Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл бүртгэнэ. Бүртгэлийг тооллогын комиссын дарга эсхүл түүний томилсон этгээд гүйцэтгэнэ.
- 7.17 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуулийн 74-р зүйлд заасан журмын дагуу хөтөлж, хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор холбогдох эрх бүхий этгээдээр баталгаажуулна. Хурлын тэмдэглэлийн тус бүр нэг хувийг гарсан шийдвэрийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад баталгаажсанаас хойш ажлын 5 хоногийн дотор хүргүүлнэ.
- 7.18 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Харин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.
- 7.19 Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.
- 7.20 Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг саналын хуудсыг хүлээн авах

сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.

- 7.21 Саналын хуудсыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор санал хураасан дүн, санал хураалтын тайланг тооллогын комисс гаргаж, ТУЗ-д хүргэнэ.
- 7.22 ТУЗ нь энэхүү дүрмэнд заасан тайланд үндэслэн шийдвэр гаргаж, шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд гарсан шийдвэрийн тухай мэдээллийг хурлын зар мэдээг хүргэдэг аргаар хүргэнэ.
- 7.23 Хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон хурлыг Компаний тухай хуульд заасны дагуу хуралдуулна.
- 7.24 Шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг видео конферц, цахим хэлбэрээр хийж болно. Цахим хэлбэрээр хийх тохиолдолд хурлын зарыг хувьцаа эзэмшигчдийн бүртгэлтэй цахим шууданд илгээх, хурлын тэмдэглэлийг хурааж баталгаажуулах, баримт бичгийг цахим хэлбэрээр илгээж хуралдаж болно.

НАЙМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

- 8.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Банкны эрх барих байгууллага нь ТУЗ байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх журам, тэдний үйл ажиллагааны болон үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх, нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Банкны тухай хууль, Монголын Компанийн засаглалын кодексийн зарчимд нийцсэн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.
- 8.2 Банкны ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 нь ердийн, 3 нь энэ дүрмийн 8.6-д заасан шалгуурыг хангасан хараат бус гишүүн байна.
- 8.3 ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжилнэ.
- 8.4 ТУЗ-ийн гишүүн мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан Банкны эрх ашгийг тэргүүн ээлжинд эрхэмлэдэг этгээд байвал зохино.
- 8.5 ТУЗ-ийн гишүүд нь Банкны тухай хуульд заасан дараахь шаардлагыг хангасан этгээд байна. Үүнд:
 - 8.5.1. Дээд боловсролтой, банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 10 (арав)-аас доошгүй жил ажилласан, үүнээс 5 (тав)-аас доошгүй жил банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашсан туршлагатай байх;
 - 8.5.2. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;
 - 8.5.3. Гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;
 - 8.5.4. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкныг удирдахад харшлахгүй байх;
 - 8.5.5. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх бүхий албан тушаалтан бол сонирхлын зөрчилгүй, банкны шийдвэр гаргах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй байх;
 - 8.5.6. Зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;
 - 8.5.7. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх.
- 8.6 Хараат бус гишүүн нь Банкны тухай хуулийн 32.1.1-32.1.6-р зүйлд заасан шалгуураас гадна дараахь шалгуурыг хангасан этгээд байна. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дараах шалгуурыг хангасан этгээд байна. Үүнд:
 - 8.6.1 Банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн мэргэжлээрээ 10 (арав)-аас доошгүй жил ажилласан, үүний 5 (тав)-аас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан туршлагатай байх;
 - 8.6.2 Тухайн банк, түүний нэгдлийн оролцогчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч биш байх;
 - 8.6.3 Тухайн банк, түүний нэгдлийн оролцогчид сүүлийн таван жилийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан, сүүлийн гурван жилийн хугацаанд бусад ажилтнаар тус тус ажиллаж байгаагүй;
 - 8.6.4 Тухайн банкны үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтээс хамаарч урамшуулал авч байгаагүй, авдаггүй байх;
 - 8.6.5 Банкны үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагад хяналт тавихад саад учруулах аливаа нөхцөл байдал үүсээгүй байх;
 - 8.6.6 Төрийн, улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй байх;
 - 8.6.7 Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон байх;
 - 8.6.8 Холбогдох этгээд биш байх;
 - 8.6.9 Банкны өрсөлдөгч аж ахуйн нэгж болон түүнд харьяалагддаг Банкны нэгдлийн аливаа оролцогч Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн нэгдмэл

- сонирхолтой этгээд биш.
- 8.7 Дор дурдсан этгээд ТУЗ-ийн гишүүн байхыг хориглоно. Үүнд:
- 8.7.1.1 эрх зүйн чадамжгүй;
 - 8.7.1.2 урьд нь эдийн засаг, аж ахуйн нэгжийн эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан;
 - 8.7.1.3 өмнө нь дампуурсан хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалд ажиллаж байсан;
 - 8.7.1.4 Компанийн тухай хуулийн 81.5.7-д заасан хугацаа өнгөрөөгүй байгаа;
 - 8.7.1.5 Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас 2 болон түүнээс дээш удаа захиргааны хариуцлага хүлээж байсан;
 - 8.7.1.6 Банкны хуульд заасан шаардлагыг хангахгүй этгээд.
- 8.8 ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо нь хууль, энэ дүрмэнд заасан шалгуурыг хангасан этгээдийн нэрийг хараат бус гишүүнд нэр дэвшүүлнэ. Хараат бус гишүүнд нэрийг нь дэвшүүлж буй этгээд нь өөрөө зөвшөөрлөө бичгээр өгсөн байх бөгөөд энэ дүрмийн 8.6-т заасан шалгуурыг хангаж байгаа гэдгээ албан ёсоор баталгаажуулсан байна. Энэхүү баталгааг хуурамчаар гаргасан нь тогтоогдвол ТУЗ-ийн дарга энэ талаар хувьцаа эзэмшигч болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэх үүрэгтэй.
- 8.9 Банкны ТУЗ-н гишүүнд нэр дэвшигч нь ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо болон хувьцаа эзэмшигчдийн хуралд дараах мэдээллийг үнэн зөвөөр тайлагнах үүрэгтэй:
- 8.9.1 нэр дэвшүүлсэн этгээдийг нэр;
 - 8.9.2 нэр дэвшигчийн нас, боловсролын байдал, ажилласан туршлага болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл;
 - 8.9.3 нэр дэвшигчийн сүүлийн 5 (таван) жилийн хугацаанд эрхэлж байсан ажил, албан тушаал;
 - 8.9.4 нэр дэвшүүлэх үед түүний эрхэлж байгаа ажил, ажил тушаал, сонгуульт ажлууд;
 - 8.9.5 нэр дэвшигч нь Банк хоорондын харилцан хамаарал байгаа эсэх;
 - 8.9.6 нэр дэвшигч нь Банкны нэгдмэл сонирхолтой этгээдтэй ямар нэг хамааралтай эсэх;
 - 8.9.7 Банкны томоохон бизнесийн түншүүдтэй ямар нэг хамааралтай эсэх;
 - 8.9.8 Нэр дэвшигчийн орлогын эх үүсвэр, болон түүний ТУЗ-ийн гишүүний ажил үүрэгт нөлөөлөхүйц бусад нөхцөл байдлын талаарх мэдээлэл.
- 8.10 ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлж ажиллахаас гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:
- 8.10.1 Банкны ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;
 - 8.10.2 ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх;
 - 8.10.3 ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд санал хураалтад оролцохгүй байх;
 - 8.10.4 хувьцаа эзэмшигчдэд Банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон Банкны засаглалын жишгийн талаар цаг тухайд нь үнэн зөв мэдээллийг бүрэн хангах;
 - 8.10.5 өрсөлдөгч Банкны ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх.
- 8.11 ТУЗ-ийн гишүүн нь үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно.
- 8.12 ТУЗ-ийн нийт гишүүдийн олонхийн саналаар ТУЗ-ийн даргыг сонгоно.
- 8.13 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих, ТУЗ-ийн зөвшөөрснөөр тодорхой асуудлаар тушаал, шийдвэр гаргах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.
- 8.14 ТУЗ нь Компанийн тухай хууль болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
- 8.14.1 Банкны үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратеги, энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;
 - 8.14.2 Банкны жил бүрийн бизнес төлөвлөгөө, төсвийг батлах;
 - 8.14.3 Банкны удирдлага, зохион байгуулалтын бүтцийг батлах;
 - 8.14.4 Банкны дотоод аудиторыг томилох, чөлөөлөх;
 - 8.14.5 хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах;
 - 8.14.6 хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 8.14.7 Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах;
 - 8.14.8 Компанийн тухай хуульд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - 8.14.9 Банкны аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцөлийг тогтоох;

- 8.14.10 ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тодорхойлох;
- 8.14.11 ТУЗ-ийн үйл ажиллагааны болон Компанийн сайн засаглалын зарчмуудыг хэвшүүлэхтэй холбоотой “Монголын Компанийн засаглалын кодекс”-г заасан бусад дотоод журмуудыг батлах;
- 8.14.12 зарласан хувьцааны тоо, төрөлд багтаан хувьцааг гүйлгээнд гаргах шийдвэр гаргах;
- 8.14.13 өөрийн гаргасан хувьцаа болон бусад үнэт цаасыг эргүүлэн авах эсхүл худалдан авах шийдвэр гаргах;
- 8.14.14 Банкныг өөрчлөн байгуулах талаар хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 8.14.15 Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 8.14.16 Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 8.14.17 эрх бүхий албан тушаалтны Банкинд учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 8.14.18 гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, хувь нийлүүлэн хөрөнгө оруулах, Банкны хөрөнгөөр баталгаа гаргах;
- 8.14.19 Банкны ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд хамаарахаас бусад асуудлыг шийдвэрлэх;
- 8.14.20 хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.
- 8.14.21 Банкны удирдлага, зохион байгуулалтын ерөнхий бүтэц захиргааны зардлын хэмжээг тогтоох;
- 8.14.22 Банкны Гүйцэтгэх захирлыг Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр томилох, түүнийг ажлаас түдгэлзүүлэх, чөлөөлөх, Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- 8.14.23 Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин шагнал урамшуулал, үүрэг хариуцлагын хэмжээг тогтоох;
- 8.14.24 Өөрийн гаргасан хувьцааг худалдах, худалдан авах, хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа бусдад худалдах, өв залгамжлуулах, бэлэглэх, гэрээслэх тухай баримт бичгийг Монголбанкинд танилцуулан зөвшөөрөл авч бүртгэх;
- 8.14.25 Салбар болон тооцооны төв, төлөөлөгчийн газар байгуулах асуудлыг шийдвэрлэх;
- 8.14.26 Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлийг ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй олгох, ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй шийдвэрлэж чадаагүй тохиолдолд уг асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж олонхийн саналаар шийдвэрлэх;
- 8.14.27 Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийг ТУЗ-ийн хараат бус гишүүнийг оролцуулан, гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэх;
- 8.14.28 Дотоод хяналтын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин урамшууллын хэмжээг тогтоох;
- 8.14.29 Санхүүгийн болон хуульд заасан бусад мэдээллийг нийтэд мэдээлэх явцад хяналт тавих;
- 8.14.30 ТУЗ нь эрх, үүргээ хэрэгжүүлэх хороодыг байгуулж, гишүүдийг томилох;
- 8.14.31 Хууль тогтоомжоор тогтоосон бусад асуудал;
- 8.14.32 Гүйцэтгэх удирдлагын хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.
- 8.15 ТУЗ-ийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.
- 8.16 ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байж болно.
- 8.17 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, Банкны гүйцэтгэх захирал болон дотоод аудитор, хараат бус Аудитын байгууллагын санаачилга, шаардлагаар хуралдуулна. ТУЗ эцнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
- 8.18 ТУЗ-ийн хурлын зохион байгуулалтыг нарийн бичгийн дарга хариуцаж, тэмдэглэл хөтөлнө. Мөн хурлын тухай зар, хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичиг, гарах шийдвэрийн төслийг ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байх бөгөөд хурал хуралдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан гишүүдэд хүргэнэ.
- 8.19 ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон ТУЗ-ийн аль нэг гишүүн хурлыг удирдана. ТУЗ-ийн дарга аливаа этгээдийг томилоогүй бол хуралд оролцож байгаа хамгийн ахмад гишүүн хурлыг удирдана. ТУЗ-өөс тодорхой асуудлыг шийдвэрлэх эрхийг ТУЗ-ийн дэргэдэх аль нэг Хороонд олгож болно.
- 8.20 ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож буй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Компанийн тухай хуульд тусгайлан заасан зарим асуудлыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй гаргана.
- 8.21 Тухайн шийдвэрлэж буй асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүд Компанийн тухай хуульд заасны дагуу санал өгөх эрхгүй бол шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 8.22 ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Гишүүн нь эсрэг саналтай байвал түүнийгээ протоколд тэмдэглүүлэх эрхтэй.
- 8.23 ТУЗ-ийн гишүүн нь саналын эрхээ бусад гишүүд болон гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

- 8.24 ТУЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, нас барсан тохиолдолд орлох гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо түр томилно. Түр томилогдсон гишүүн нь энэ дүрэмд заасан шаардлагыг хангасан байна. Хараат бус гишүүнд нэр дэвшсэн боловч сонгогдож чадаагүй гишүүдийн дотроос нөхөн сонгох асуудлыг тэргүүн ээлжинд дэвшүүлж болно.
- 8.25 ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос 2 дахин бага болсон тохиолдолд Банк нь 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.
- 8.26 ТУЗ-ийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 8.26.1 ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлж хяналт тавих, үнэн зөвийг хариуцах;
 - 8.26.2 хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;
 - 8.26.3 хувьцаа эзэмшигчдийн жил бүрийн ээлжит хурлын бэлтгэлийг энэ дүрэмд заасны дагуу хангаж байгаа эсэхэд хяналт тавих, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг гаргасан байх асуудлыг ТУЗ-ийн дарга биечлэн хариуцах ёстой;
 - 8.26.4 ТУЗ-өөс олгосон бусад эрх хэмжээ.
- 8.27 ТУЗ-ийн гишүүд нь зохих хэмжээний урамшуулал авах бөгөөд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно.
- 8.28 Шаардлагатай тохиолдолд ТУЗ-н ээлжит болон ээлжит бус хурлыг видео конференц, цахим хэлбэрээр хийж болно. Цахим хэлбэрээр хийх тохиолдолд хурлын зарыг ТУЗ-н гишүүдийн бүртгэлтэй цахим шууданд илгээх, хурлын тэмдэглэлийг хурааж баталгаажуулах, баримт бичгийг цахим хэлбэрээр илгээж хуралдаж болно.

ЕС. ТУЗ-ЫН ДЭРГЭДЭХ ХОРООД

- 9.1 Банкны ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Аудитын, Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын, Эрсдэлийн удирдлагын хороотой байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна.
- 9.2 **Аудитын хороо**
- 9.2.1 ТУЗ-ийн Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн байх бөгөөд санхүү, бүртгэл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байна.
 - 9.2.2 ТУЗ-ийн Аудитын хороо нь дараах чиг үүрэгтэй байна. Үүнд:
 - 9.2.2.1 Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;
 - 9.2.2.2 Банкны үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээллийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;
 - 9.2.2.3 дотоод аудиторыг томилох, цалин урамшууллын талаарх гүйцэтгэх удирдлагын саналыг хянах, ТУЗ-д танилцуулах;
 - 9.2.2.4 хөндлөнгийн Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн Аудитын байгууллагад чиглэл өгөх /чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар Аудитын байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ;
 - 9.2.2.5 их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих;
 - 9.2.2.6 Банкны ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.
- 9.3 **Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хороо**
- 9.3.1 ТУЗ-ийн нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын хороо нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:
 - 9.3.1.1 ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;
 - 9.3.1.2 ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигч нь ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд хууль, дүрмэнд заасан шалгуурыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;
 - 9.3.1.3 ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх /саналын хуудсанд шууд нэрийг нь оруулах/;
 - 9.3.1.4 ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;
 - 9.3.1.5 Гүйцэтгэх захирал, багийн гишүүдтэй байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох;
 - 9.3.1.6 ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;
 - 9.3.1.7 эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний

хэрэгжилтэд хяналт тавих;

9.3.1.8 эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах;

9.3.1.9 Банкны цалин урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;

9.3.1.10 Банкны ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

9.3.2 ТУЗ-д нэр дэвшсэн аливаа этгээдийн нэрийг саналын хуудсанд оруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэхдээ тухайн этгээд нь дараах нөхцөл байдлыг хянах үүрэгтэй. Үүнд:

9.3.2.1 Банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагын талаарх шаардлагыг хангаж байгаа эсэх;

9.3.2.2 жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулаагүй, эсхүл зохих журмын дагуу хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон ТУЗ-д ажиллаж байсан эсэх;

9.3.2.3 өмнө Банкны ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан этгээдийн нэрийг дахин дэвшүүлж байгаа бол ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэх;

9.3.2.4 Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эсэх.

9.4 Эрсдэлийн удирдлагын хороо

9.4.1 Эрсдэлийн удирдлагын хороо нь дараах чиг үүрэгтэй. Үүнд:

9.4.1.1 Банкны эрсдэлийн ерөнхий түвшинд нийцсэн эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

9.4.1.2 Банкны гүйцэтгэх удирдлагын зүгээс зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, хууль эрх зүй, нэр хүндийн болон бусад төрлийн эрсдэлийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалттай байгаа эсэхэд хяналт тавих;

9.4.1.3 Дотоод Аудитын албаны банкны эрсдэлийн удирдлагад хийсэн Аудитын шалгалтын акт, материалтай тухай бүр танилцаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах;

9.4.1.4 Санхүүгийн хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулсан эсэхэд хяналт тавих.

АРАВ. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

10.1 ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн даргын санал болгосон этгээдийг ТУЗ томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллах этгээд нь Компанийн засаглалын асуудлаар сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна. Нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.

10.2 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд түүнийг сонгох, үйл ажиллагааг нь зохицуулах хянахтай холбоотой нарийвчилсан асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно. Үүнд:

10.2.1 Компанийн засаглалын талаар бодлого боловсруулахад оролцох;

10.2.2 Бүрэн эрхийнхээ хүрээнд Банкны ажилтнууд Банкны засаглалын бодлогыг дагаж мөрдөх, Банкинд сайн засаглалын практикийг хэвшүүлэх үйл явцыг удирдан чиглүүлэх арга хэмжээ авах;

10.2.3 Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний хороодын хуралд бэлдэх, зарлах, хуралдуулах арга хэмжээг зохион байгуулах;

10.2.4 Банкны ТУЗ нь гүйцэтгэх албаны хэлтэс газрууд үр дүнтэй мэдээлэл солилцох тогтолцоог хариуцах;

10.2.5 Мэдээллийг нийтэд хүргэх арга хэмжээ авах замаар Банкны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;

10.2.6 Хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талаас ТУЗ-д ирүүлсэн аливаа санал, гомдол хүсэлтийг шийдвэрлэхэд оролцох, Банк доторхи маргааныг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах, санал боловсруулах;

10.2.7 Хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий сонирхогч этгээд Компанийн тухай хууль болон энэ дүрмээр тогтоосон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх боломж олгох;

10.2.8 Компанийн сайн засаглалын талаар олон улсын болон бусад компанийн туршлага, төрийн болон төрийн бус байгууллагаас энэ талаар дэвшүүлж буй санал санаачлагыг судлах замаар Банкны засаглалыг цаашид сайжруулах санал боловсруулах.

АРВАН НЭГ.ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН

11.1 ТУЗ-ийн хараат бус гишүүд нь бусад гишүүдтэй адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

11.1.1 ТУЗ, гүйцэтгэх удирдлагын шийдвэр нь хууль тогтоомж, Банкны дүрэм болон холбогдох дотоод журмуудад нийцэж байгаа эсэх, Банкны эрх ашигт сөргөөр нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавих, ийм зөрчилтэй шийдвэр гаргахаас сэргийлэх, гаргасан бол зөрчлийг арилгахыг шаардах, шаардлагыг эс биелүүлбэл асуудлыг ТУЗ-д тавьж хэлэлцүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахыг шаардах, хуралдуулаагүй тохиолдолд 2-оос доошгүй хараат бус гишүүн хамтран хурал зарлан хуралдуулах;

- 11.1.2 Банкны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
- 11.1.3 хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах;
- 11.1.4 Банкны ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

АРВАН ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

- 12.1 Банкны гүйцэтгэх удирдлага нь энэ дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.
- 12.2 Банкны гүйцэтгэх удирдлагыг Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 12.3 Гүйцэтгэх захирал нь Банкны тухай хуулийн 32.1.1-32.1.6-р зүйлд заасан шалгуураас гадна дараах шалгуурыг хангасан байна. Үүнд:
 - 12.3.1. Банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний 5 (тав)-аас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага, туршлагатай;
 - 12.3.2. Банк, банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй сонирхлын зөрчилгүй, нэгдмэл сонирхолтой этгээд биш байх;
 - 12.3.3. Бусад банк, түүний нэгдэл, эсхүл банкттай харилцан хамаарал бүхий санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан биш байх;
 - 12.3.4. Монголбанкны эрх бүхий албан тушаалтнаар сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаагүй байх;
 - 12.3.5. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхээ хасуулаагүй байх;
 - 12.3.6. Банкны хууль тогтоомж, Монголбанкны шийдвэрийг ноцтой зөрчиж байгаагүй;
 - 12.3.7. Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомж, банкны дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.
- 12.4 Банкны үйл ажиллагааны тодорхой төрлийн асуудлаар Гүйцэтгэх захиралд зөвлөмж өгөх чиг үүрэг бүхий хороо, зөвлөл ажиллаж болно. Хороо, зөвлөлийн ажиллах журмыг Гүйцэтгэх захирал тогтооно.
- 12.5 Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал, нөхөн олговор, ногдох хариуцлага зэрэг асуудлыг ТУЗ-өөс тогтоон, гэрээнд тусгана.
- 12.6 Гүйцэтгэх захирал ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга болон гишүүнд гаргаж болно.
- 12.7 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн Аудитын, цалин урамшууллын, Нэр дэвшүүлэх, үнэлгээ, урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох бөгөөд гүйцэтгэх захирлыг сонгох, томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, хяналт тавихтай холбоотой асуудлаар шийдвэр гаргахад саналын эрхгүй байна.
- 12.8 Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг**
- 12.8.1 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд Банкны нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар Банкийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө. Үүнд:
 - 12.8.1.1 Банкны стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөөний төсөл боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.
 - 12.8.1.2 Банк, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн захирлуудыг томилох, ажилтнуудтай Банкийг төлөөлөн хөдөлмөрийн ба үр дүнгийн гэрээ байгуулна;
 - 12.8.1.3 Банкны хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулна;
 - 12.8.1.4 Банкны Хөдөлмөрийн дотоод журмыг батална.
 - 12.8.1.5 өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана;
 - 12.8.1.6 Банкийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулна;
 - 12.8.1.7 Банкийг төлөөлөх итгэмжлэл олгоно;
 - 12.8.1.8 Банкны ажиллагсдын хөдөлмөрийн сахилга бат, хөдөлмөр хамгаалалтын дэг журмын хэрэгжилт, технологийн горимын хэрэгжилт болон аж ахуй санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалтад хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
 - 12.8.1.9 Монгол улсын хууль, тогтоомж болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна;
 - 12.8.1.10 Банк түүний бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулж ТУЗ-д танилцуулах, ажлын байрны шаардлагыг тогтоон уг шаардлагад нийцсэн ажилтан, албан хаагчдын баг бүрдүүлэх;
 - 12.8.1.11 Банкны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна;
 - 12.8.1.12 хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-ийн хурлын шийдвэр, Банкны санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангана;
 - 12.8.1.13 Банкны улирал, жилийн үйл ажиллагааны талаар ТУЗ-ийн хуралд тайлан тавьж хэлэлцүүлнэ. Энэхүү тайланд тухайн хугацаад хийсэн гэрээ, хэлцлийн дотор Банкны аль нэг эрх бүхий албан

- тушаалтны хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл байсан эсэх, байсан бол тухайн хэлцлийг Компанийн тухай хуулин 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай асуудлыг тусгасан байна;
- 12.8.1.14 Энэ дүрэм болон холбогдох хууль тогтоомж, банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, ТУЗ-ийн тогтоол, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, Монголбанкнаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- 12.8.1.15 Хувьцаа эзэмшигчид, банкны харилцагчийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх, Банкны санхүүгийн төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
- 12.8.1.16 Банк, банкны хадгаламж эзэмшигчид, харилцагчдийн эрх ашгийг хувийн эрх ашгаас илүүд тавьж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллах;
- 12.8.1.17 Үүрэг гүйцэтгэх явцад олж авсан Банк, банкны харилцагчийн талаархи мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх, нууцыг чандлан хадгалах;
- 12.8.1.18 ТУЗ-өөс баталсан зардлын хэмжээнд багтаан Банкны ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох, олгох;
- 12.8.1.19 Ажилтнуудын ажил үүргийн хуваарийг тогтоох, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх;
- 12.8.1.20 Банкны газар, нэгж, салбар, тооцооны төв, касс, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг удирдлагаар ханган, тэдгээрийн удирдлага, ажилтнуудыг томилох, ажлаас чөлөөлөх;
- 12.8.1.21 Олгогдсон эрх хэмжээний хүрээнд банкны нэрийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргах, гэрээ хэлэлцээрт гарын үсэг зурах;
- 12.8.1.22 Банкны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тушаал гаргаж биелэлтийг хангуулах;
- 12.8.1.23 Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;
- 12.8.1.24 Хороо, зөвлөлийн үйл ажиллагааг удирдаж, шаардлагатай асуудлуудаар санал авах;
- 12.8.1.25 Энэ дүрэмд болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан үүргээ биечлэн гүйцэтгэх буюу түүнийг томилсон этгээдэд эрхээ шилжүүлэх замаар гүйцэтгүүлэх;
- 12.8.1.26 Гүйцэтгэх захирал өөрт нь болон өөртэй нь холбогдох этгээдэд банктай бизнесийн харилцаанд орсон этгээдийн санхүүгийн үр дүнг сонирхох шалтгаан байгаа бол сонирхлын зөрчил байна гэж үзэж, энэ тухайгаа нэн даруй ТУЗ-д бичгээр мэдэгдэх;
- 12.8.1.27 Гүйцэтгэх захиралд энэ дүрмэнд заагдсан банкны ажилтанд тавигдах ёс зүйн шаардлагууд нэн түрүүнд хамаарна;
- 12.8.1.28 Санхүүжилт, зээлжүүлэлттэй холбогдсон хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээртэй байгуулсан гэрээний үндсэн дээр холбогдох мэдээ тайланг харилцагчаас шаардан авах, тэдний тайлан тэнцэлтэй танилцах, шалгах, хууль тогтоомжийн дагуу хөрөнгийг барьцаанд авах, дансны гүйлгээг түр хаах;
- 12.8.1.29 Банкинд учруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, банкинд холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;
- 12.8.1.30 Хувийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх;
- 12.8.1.31 Банк, түүний салбар нэгжийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээ, нэг этгээдэд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох, зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийж хяналт тавих;
- 12.8.1.32 Шаардлагатай гэж үзвэл хадгаламж эзэмшигч, харилцагчдын болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тухайн салбар нэгжийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон тусгай дүрэм журам гаргах, салбар нэгжийн үйл ажиллагаанд тодорхой хязгаарлалт тогтоох зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- 12.8.1.33 Банкнаас хөрөнгө захиран зарцуулах төлбөрийн баримтанд гарын үсэг зурах;
- 12.8.1.34 Хууль тогтоомжид болон ТУЗ-тэй байгуулах гэрээнд заасан бусад эрх үүрэг.
- 12.8.2 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга болон гишүүнд гаргаж болно. Энэхүү саналыг гаргахдаа хэлэлцүүлэх асуудлын талаарх танилцуулга, гарах шийдвэрийн төсөл зэргийг хүргүүлнэ.
- 12.8.3 Гүйцэтгэх захирал ээлжийн амралт эдлэх, гадаад дотоодод албан томилолтоор ажиллах, удаан хугацаагаар өвчлөх тохиолдолд өөрийн эрх үүргийг бүхэлд нь Банкны хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу эрх бүхий этгээдэд шилжүүлнэ. Түүнчлэн Гүйцэтгэх захирал тодорхой бүрэн эрхээ банкны албан тушаалтнууд болон ажилтнуудад итгэмжлэн хариуцуулж болно. Ийнхүү өөрийн эрх үүргийг бүхэлд нь буюу итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 12.8.4 Банкны зээл, хадгаламжийн хүү, үйлчилгээний комисс, шимтгэлийн хэмжээг Актив пассивын удирдлагын хороогоор хэлэлцүүлж Гүйцэтгэх захирал тогтооно.
- 12.8.5 Гүйцэтгэх захирал нь Банкны тухай хууль тогтоомж, энэхүү дүрэм, гэрээнд заасан үүрэг болон Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах талаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол түүнийг ТУЗ-өөс үүрэгт ажлаас нь чөлөөлнө.

АРВАН ГУРАВ. БАНКНЫ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙН ХАРИУЦЛАГА

- 13.1 ТУЗ-ийн дарга, гишүүн, Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, ерөнхий нягтлан бодогч, газрын захирлууд нь Банкны эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 13.2 Банкны эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй. Үүнд:
- 13.2.1 Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, Банкны эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;
- 13.2.2 ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд Банкны нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;
- 13.2.3 шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;
- 13.2.4 шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;
- 13.2.5 өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх;
- 13.3 Эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.
- 13.4 Албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 5 жилийн хугацаанд энэ дүрмийн 13.2.2-т заасан үүргийг хүлээнэ.
- 13.5 Албан тушаалтан энэ дүрмэнд заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрийн дор дурдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас Банк, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна. Үүнд:
- 13.5.1 Банкны нэрийг хувийн сонирхлоор ашигласан;
- 13.5.2 хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч, бусад оролцогчдод хуурамч мэдээлэл өгсөн
- 13.5.3 эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;
- 13.5.4 Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан Банкны баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй;
- 13.6 Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгснөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар Банкинд торгуулийн арга хэмжээ оногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.
- 13.7 Банкны эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, Банкны дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРВАН ДӨРӨВ. БАНКНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРТГЭЛ ТАЙЛАН

- 14.1 **Банкны нягтлан бодох бүртгэл, тайлан**
- 14.1.1 Банк нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувь нийлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.
- 14.1.2 Банкны санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.
- 14.1.3 Банк нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг Банкны гүйцэтгэх захирал хариуцна. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг ерөнхий нягтлан бодогч, санхүүгийн захирал, гүйцэтгэх захиралтай хамтран хариуцна.
- 14.1.4 Банк дор дурдсан бүртгэлийг заавал хөтлөх бөгөөд бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх, холбогдох бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалсан байх нь гүйцэтгэх захирлын хариуцах асуудал болно. Үүнд:
- 14.1.4.1 Банкны хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг, холбоо барих утас, цахим шуудангийн хаяг, эзэмшиж буй үнэт цаасн төрөл, тоо зэрэг мэдээллийг тусгана. **Хаалттай** санал болгон гаргасан үнэт цаасны бүртгэлийг үнэт цаасны хадгаламжийн байгууллагатай гэрээ байгуулан хөтлүүлнэ;
- 14.1.4.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон хурлын шийдвэр, хуралд зориулан хувьцаа эзэмшигчдэд тараасан материал, хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлын талаар ирүүлсэн саналын бүртгэл. Хурал, хурлын шийдвэрийн бүртгэлд хурал хийсэн байр, он, сар, өдөр, хурлын дарга, протокол хөтөлсөн этгээдийн овог, нэр, гишүүдийн ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэр;
- 14.1.5 ТУЗ-ийн хурал, хурлын шийдвэрийн бүртгэл;
- 14.1.5.1 Банкны дүрэм, түүнд орсон өөрчлөлтийн бүртгэл

- 14.1.5.2 Банкны болон эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэл;
- 14.1.5.3 Банкны хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээдийн бүртгэл;
- 14.1.5.4 төрийн эрх бүхий хяналт, зохицуулалтын байгууллагад хүргүүлсэн мэдээ, тайлангийн бүртгэл;
- 14.1.5.5 хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагаас баталсан Банкны засаглалын, хөдөлмөрийн, цалин урамшууллын, хөдөлмөр хамгааллын гэх мэт дотоод журам, зааврын бүртгэл;
- 14.1.5.6 Банкны санхүүгийн тайланд болон ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий бусад этгээдийн хүсэлтээр хийсэн Аудитын шалтгалтын тайлангийн бүртгэл;
- 14.1.5.7 Банкны бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийн бүртгэл;
- 14.1.5.8 ТУЗ болон гүйцэтгэх захирлын шийдвэрээр тогтоосон бусад бүртгэл.
- 14.2 Энэхүү дүрмийн 14.1-т заасан бүртгэлтэй холбогдох үндсэн бичиг баримт болон дор заасан бичиг баримтыг хадгална. Үүнд:
 - 14.2.1 Банкны улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлүүд, лиценз;
 - 14.2.2 Банкны өмчлөл болон эзэмшилд байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт;
 - 14.2.3 анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт;
 - 14.2.4 салбар төлөөлөгчийн газрын дүрэм;
 - 14.2.5 гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр
 - 14.2.6 ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт;
- 14.3 Холбогдох бичиг баримтыг хууль, журмын дагуу байгууллагын архивт шилжүүлнэ. Харин Банкны дүрэм, хүчин төгөлдөр гэрээ, тусгай зөвшөөрөл зэргийг байнга хадгална.
- 14.4 Банк нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.
- 14.5 Санхүүгийн тайланд дараах үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна. Үүнд:
 - 14.5.1 баланс;
 - 14.5.2 орлогын, үр дүнгийн тайлан;
 - 14.5.3 мөнгөн гүйлгээний тайлан;
 - 14.5.4 хуримтлагдсан ашгийн тайлан;
 - 14.5.5 нэмэлт, тайлбар, тодруулга;
 - 14.5.6 тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт;
 - 14.5.7 эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин урамшууллын дүн, албан тушаалтан бүрээр нэрээр
 - 14.5.8 Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга.
- 14.6 Санхүүгийн тайланг гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин Банкуудад оруулсан хөрөнгө оруулалт, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.
- 14.7 Банк санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторийг томилон ажиллуулна.
- 14.8 Санхүүгийн тайланг Банкны ТУЗ-ийн зөвшөөрлөөр томилогдсон хөндлөнгийн Аудитын байгууллагаар хянуулах бөгөөд ТУЗ санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хэлэлцүүлнэ.
- 14.9 Санхүүгийн тайлан нь тэнцэл, орлого, зарлагын болон мөнгөн хөрөнгийн хөдлөлийн тайлан, тайлбар, тодруулгаас бүрдэнэ.
- 14.10 Санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт нь олон улсын жишгийг үндэслэн Монголбанкнаас тогтоосон нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцсэн байх бөгөөд тайланг үнэн зөв гаргасан гэдгээ албан ёсоор нотолсон баримт бичиг үйлдэн, огноог тэмдэглэж, банкны эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарсан байна.
- 14.11 Банк санхүүгийн тайлангаа сар бүрийн байдлаар дараа сарын 10-ны өдрийн дотор, улирал бүрийн байдлаар дараа улирлын эхний сарын дотор Монголбанкинд гаргаж өгнө.
- 14.12 Банк санхүүгийн тайлангаа аудитаар хуульд заасан хугацаанд шалгуулж, баталгаажуулна.
- 14.13 Банк улирлын санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын дотор, аудитаар баталгаажсан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд батгаан нийтэд хэвлэлээр мэдээлж байна.
- 14.14 Санхүүгийн тайлангуудын үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч хариуцна.
- 14.15 Банкны дотоод Аудитын нэгж нь банкны өдөр тутмын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн ажиллагаа холбогдох заавар журмын дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавьж, ажлаа Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагад тайлагнана.
- 14.16 Дотоод хянан шалгагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 14.16.1. Батлагдсан хуваарийн дагуу ээлжит болон гэнэтийн шалгалтыг салбар нэгжүүдэд явуулах;
 - 14.16.2. Үйл ажиллагаа явуулах зорилгоор салбар нэгжүүдэд чөлөөтэй нэвтрэн орох;

- 14.16.3. Салбар нэгжүүдийн санхүүгийн баримтанд хяналт шалгалт хийх, тайлбар лавлагаа гаргуулж авах асуулт тавьж хариулт авах;
- 14.16.4. Шаардлагатай гэж үзсэн баримт материалын хуулбарыг салбар нэгжүүд, харилцагч иргэд, хуулийн этгээдээс гаргуулан авах;
- 14.16.5. Шаардлагатай асуудлаар шууд Төлөөлөн удирдах зөвлөл, ХШЗ-д хандаж, үнэн зөв мэдээллээр хангах;
- 14.17 Банк санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр хөндлөнгийн аудиторыг томилно.
- 14.18 Аудиторыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг Төлөөлөн удирдах зөвлөл батална. Гэрээнд банкны болон аудиторын эрх үүрэг, хариуцлага, аудиторд төлөх хөлсний хэмжээг заана.
- 14.19 Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн хуралд зөвхөн тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.
- 14.20 Нэгдмэл сонирхолтой этгээд, банкны эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, банкны буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтныг аудиторoor сонгон ажиллуулахыг хориглоно.
- 14.21 Банкны ТУЗ нь санхүүгийн тайлан, түүнд хавсаргасан нэмэлт тайлбар тодруулга, тайлангийн талаарх Аудитын болон ТУЗ-ийн дүгнэлтээс гадна дараах мэдээллийг тусгасан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичнэ:
- 14.21.1 Банкны бүтэц зохион байгуулалт түүнд гарсан өөрчлөлт;
- 14.21.2 тайлангийн хугацаанд Банкны эрхлэн явуулсан үйл ажиллагаа тус бүрийн талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт, үр дүн;
- 14.21.3 Банкны өмчлөл, эзэмшилд байгаа эдийн болон эдийн бус хөрөнгө, тусгай зөвшөөрөл зэргийн талаарх мэдээлэл, эдгээрт гарсан өөрчлөлт.
- 14.21.4 Банкны гүйцэтгэх захирал нь энэ дүрмийн 14-т заасан мэдээлэлтэй танилцах боломжоор хувьцаа эзэмшигчдийг хангана.

АРВАН ТАВ. НОГДОЛ АШИГ

- 15.1 Банкны ногдол ашгийн бодлого болон холбогдох бусад хууль тогтоомжинд заасныг удирдлага болгон ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Монголбанкны зөвшөөрөлтэйгээр ТУЗ гаргаж болно. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.
- 15.2 Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн Банкны болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.
- 15.3 Банкны жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна. Үүнд:
- 15.3.1 ногдол ашиг төлсний дараа Банк төлбөрийн чадвартай байх;
- 15.3.2 ногдол ашиг төлсний дараа Банкны өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, энэ дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
- 15.3.3 Банк эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх;
- 15.3.4 Монголбанкнаас зөвшөөрлийг авсан байх (хэрэв шаардлагатай бол).
- 15.4 Ногдол ашиг хуваарилсны дараа Банкны өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.
- 15.5 Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.
- 15.6 Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээний санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болох бөгөөд уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө.
- 15.7 Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкин дах дансанд шилжүүлэх бодлого баримтална.
- 15.8 Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед ногдол ашгийн хуваарилалтын тайланг гаргаж Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

АРВАН ЗУРГАА. БАНКНЫ САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

16.1 Дотоод хяналт

- 16.1.1** Банкны гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн Аудитын хороо болон ТУЗ-аас томилсон Дотоод аудиторoor дамжуулан хэрэгжүүлнэ. Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын ажилтныг Гүйцэтгэх захирал томилон ажиллуулж болно.
- 16.1.2** Дотоод аудитор нь Банкны үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтан байх бөгөөд ТУЗ-өөс томилогдож, ТУЗ-ийн баталсан “Дотоод Аудитын дүрэм”-ийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 16.1.3** Дотоод аудитор нь Банкны ажилтан албан хаагчдын ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.
- 16.1.4** Дор дурдсан этгээдийг дотоод аудиторoor ажиллуулахыг хориглоно. Үүнд:
- 16.1.4.1** Эрх зүйн чадамжгүй;
 - 16.1.4.2** Урьд нь дампуурсан Банкны удирдлагад ажиллаж байсан;
 - 16.1.4.3** Банкны эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээд эсвэл ямар нэг шалтгаанаар тэдний нөлөөнд автах боломжтой/ найз нөхрийн болон өмнө хамт ажиллаж байсан зэргээр холбоо харилцаатай/;
 - 16.1.4.4** Өмнө нь авилгын хэрэгт шүүхээс ял шийтгэгдэж байсан.
- 16.1.5** Дотоод аудиторын шалгалтын хуваарь, шалгалтын хэлбэрийг Дотоод аудиторын дүрмээр тодорхойлно.

16.2 Аудиторын /хөндлөнгийн/ хяналт

- 16.2.1** Аудитын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу Банк нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн Аудитын байгууллагыг сонгон гэрээ байгуулж, ажиллуулна.
- 16.2.2** Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх Аудитын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.
- 16.2.3** Банкны жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.
- 16.2.4** Ээлжит бус шалгалтыг ТУЗ, түүний Аудитын хорооны шийдвэр, Банкны энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх захирлын саналаар хэдийд ч хийж болно.
- 16.2.5** Банкны ТУЗ-ийн Аудитын хороо Аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд Банкны болон Аудитын байгууллагын эрх үүрэг, хариуцлага, Аудитын үйлчилгээний хөлсний хэмжээг заана. Аудитын дүгнэлтийн шинж чанараас хамааруулан Аудитын хөлсний хэмжээг тогтоохыг хориглоно.
- 16.2.6** Аудитын ээлжит шалгалтын хөлсийг Банк хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтыг түүнийг захиалж, гэрээ байгуулж хийлгэсэн хувьцаа эзэмшигч хариуцаж төлнө. Шалгалтын явцад Банкны эрх бүхий албан тушаалтан Банкинд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнө.
- 16.2.7** Банкны эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар Банкны санхүү-эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.
- 16.2.8** Эрх бүхий албан тушаалтан энэ дүрмэнд заасан үүргээ хэрэгжүүлээгүйгээс аудиторын ажил зогссон хоногт оногдох ажлын хөлсийг буруутай албан тушаалтан хариуцан төлнө. Энэ тухай шийдвэрийг Аудитын Банкаас ирүүлсэн албан ёсны хүсэлтийг үндэслэн ТУЗ гаргана. Харин дээрх шалтгаанаар аудиторын ажил зогссон тухайд Аудитын компани ТУЗ-ийн Аудитын хорооны даргад албан ёсоор мэдэгдсэн байна.
- 16.2.9** Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд гаргасан дүгнэлтийнхээ талаар тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.

16.3 Дараах этгээдийг Банкны аудиторoor сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:

- 16.3.1** Банктай нэгдмэл сонирхолтой этгээд, Банкны эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд Банкны буюу нэгдмэл сонирхолтой Банкны хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;
- 16.3.2** Банкны болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хувьцаа эзэмшигч, эсхүл Банкны болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол;
- 16.3.3** Банктай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол.

16.4 Аудитор нь дүгнэлтээ зөвхөн бичгээр гаргах бөгөөд дүгнэлтэд дараах асуудлыг заавал тусгасан байна. Үүнд:

- 16.4.1** Банкны санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх;
- 16.4.2** нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил илэрсэн бол зөрчлийг тохиолдол тус бүрээр тодорхойлсон;
- 16.4.3** шалгалтын хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, эдгээр хэлцлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай дүгнэлт;
- 16.4.4** Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржээс тогтоосон бусад мэдээлэл;
- 16.4.5** ТУЗ-ин Аудитын хорооны саналаар Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бусад асуудлын талаарх мэдээлэл, дүгнэлт;

АРВАН ДОЛОО. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ

- 17.1 Банкны үйл ажиллагаанд гарч болох Банк түүний бизнесийн түншүүд /зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч г.м/, ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид зэргийн хооронд гарсан аливаа зөрчил маргаан, сонирхлын зөрчлийг хэлэлцэн тохирох замаар зохицуулах нь ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын анхаарлын төвд байх асуудал болно.
- 17.2 Аливаа зөрчил, маргаан үүссэн үед Банкны эрх зүйн хэлтэс /хуулийн зөвлөх/ шалтгааныг судалж, хэрхэн шийдвэрлэж болох тухай саналаа холбогдох дээд шатны удирдлагад танилцуулна.
- 17.3 Энэ дүрмэнд заасан саналыг холбогдох удирдлага судалж үзээд зохих арга хэмжээ авах замаар зөрчлийг зохицуулах үүрэгтэй.
- 17.4 Зөрчил маргаан нь эрх бүхий албан тушаалтнуудын хооронд гарсан, эрх бүхий албан тушаалтан болон бусад оролцогч талуудын хооронд гарсан /зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч, ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид г.м/ бол зөрчил маргааныг шийдвэрлэхэд тухайн сонирхлын зөрчилтэй эрх бүхий албан тушаалтан оролцохгүй.
- 17.5 Банк нь Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхдээ дараах журмыг баримтална. Үүнд:
- 17.5.1 Банктай болон холбоотой компанитай хийж буй аливаа хэлцэлд тухайн хэлцлийг хийх талаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцох эрх бүхий аль нэг албан тушаалтан оролцож байгаа /өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, эсхүл хэлцэлд зуучлагч төлөөлөгч болж байгаа, эсхүл хэлцлээс шууд болон шууд бусаар орлого хүртэж байгаа бол оролцож байгаа гэж үзнэ/ бол тухайн албан тушаалтан энэ тухайгаа хэлцэл хийх шийдвэр гаргах үед гүйцэтгэх захиралд болон Аудитын хорооны даргад мэдэгдэнэ. Гүйцэтгэх захирал өөрөө хэлцэлд оролцогч этгээд бол ТУЗ-ийн даргад мэдэгдэнэ;
- 17.5.2 хэлцэл хийх шийдвэр гаргах болон хэлцэлтэй холбогдох үнэ тогтооход хэлцэлд оролцож буй эрх бүхий албан тушаалтан оролцож, санал өгөхгүй;
- 17.5.3 хэлцэл хийхэд оролцох этгээд гэдгээ мэдээгүй, сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас Банкинд хохирол учруулсан бол эрх бүхий албан тушаалтан уг хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.
- 17.6 Компанийн тухай хуулийн 92.3-т заасны дагуу шийдэж чадаагүй тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

**АРВАН НАЙМ. БАНКИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ,
ТАТАН БУУЛГАХ**

- 18.1 Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах үйл ажиллагааг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон Монголбанкнаас баталсан журамд заасны дагуу хэрэгжүүлнэ.
- 18.2 Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авна.

АРВАН ЕС. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 19.1 Энэ дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон, энэ асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхиор баталж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн албанд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.
- 19.2 Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн 19.1-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

ХОРЬ. БУСАД

- 20.1 Энэхүү дүрэм нь аливаа байдлаар хууль тогтоомжтой зөрчилдөх тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн заалтыг дагаж мөрдөнө. Энэхүү дүрэмд шууд заагаагүй буюу тусгагдаагүй аливаа асуудлыг холбогдох хууль тогтоомжийн заалтыг дагаж мөрдөнө.

—ооОоо—

БОГД БАНК ХК-ИЙГ ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛГОХ ТУХАЙ ТӨСӨЛ

НЭГ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Монгол улсын “Компанийн тухай” хуульд зааснаар:

Компанийн тухай хуулийн 3.6-д “Хувьцаат компани нь нээлттэй болон хаалттай гэсэн төрөлтэй байна.”

Компанийн тухай хуулийн 3.7-д "Нээлттэй хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ.

Компанийн тухай хуулийн 3.8-д "Хаалттай хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагддаг компанийг хэлнэ.

“Банкны тухай” хуульд зааснаар:

Банкны тухай хуулийн 4.2-т “Банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, бусад банк нь хувьцаат компанийн хэлбэртэй байна.”

ХОЁР. ЗОРИЛГО

Богд банк нь 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр “Банкны тухай хууль”-д орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу 2021 оны 12 дугаар сард компанийн хэлбэрийг өөрчилж нийт энгийн хувьцааны 20% буюу 12,500,000 ширхэг хувьцааг зах зээлд нэмж гарган нэгж хувьцааг 2,540 төгрөгөөр арилжаалж нээлттэй хувьцаат компани хэлбэртэй болсон. Банкны жижиг хувьцаа эзэмшигчдийн тоог нэмэгдүүлэх, хувьцааны төвлөрлийг бууруулах, хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор 2023 оны 3 дугаар сард нэгж хувьцааг 20 тэнцүү хэсэгт хуваан, нэгж хувьцааны нэрлэсэн үнийг 80 төгрөг хүргэж бууруулах ажлыг амжилттай гүйцэтгэсэн ба 2024 оны 11 дүгээр сарын байдлаар Богд банкны нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 1,260-с 3,572 болж нэмэгдсэн байна.

Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан “Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байна” гэсэн шаардлагыг хангах зорилтын хүрээнд Богд банк ХК нь банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн хувьцааг хөрөнгө оруулагчдад санал болгон арилжих ажил 2021 оноос эхлэн тогтмол хийгдэж байгаа ба тус үйл ажиллагаанд зориулан 2022 онд “Олон улсын харилцаа хамтын ажиллагаа”-ны бие даасан хэлтсийг шинээр байгуулж олон улсын боломжит хөрөнгө оруулагч банк, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулалтын сангуудтай тогтмол уулзалт зохион байгуулж хамтран ажилласаар ирсэн билээ.

Монголын хөрөнгийн зах зээлийн багтаамж бага, хөрвөх чадвар муу, бирж дээр нээлттэй арилжаалагдаж буй хувьцаа болон арилжааны эрэлтийн хэт зөрүүтэй байдлаас үүдэн компанийн зах зээлийн үнэлгээ бодит түвшнээс хэт доогуур байгаа нь олон улсын хөрөнгө оруулагчдыг татах, хувьцааны төвлөрлийг бууруулж дээр дурдсан “Банкны тухай хууль”-ийн холбогдох шаардлагуудыг хангахад сөргөөр нөлөөлж байна.

Банк нь хаалттай хувьцаат компани болсноор “Компанийн тухай хууль”-ийн 3.8 дахь заалтын дагуу одоогийн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдсэн хэвээр үлдэх бөгөөд хувьцааны арилжаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага /Монголын хөрөнгийн бирж/-аас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагдахын зэрэгцээ олон улсын стандарт, аргачлалын дагуу компанийн үнэлгээ тогтож, хувьцаа эзэмшигчдийн хувьцааны үнэлгээ нь компанийн үйл ажиллагааны цар хүрээ, санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд болон цэвэр ашгийн өсөлттэй уялдан бодит зах зээлийн үнэлгээнд хүрэх боломжтой гэж үзсэн төдийгүй хаалттай хувьцаат компани болсноор зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан банкны шийдвэр гаргах хурд нэмэгдэх, үйл ажиллагааны зардлыг бууруулах, урт хугацааны зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөөтэй гэж үзсэний үндсэн дээр банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс тус шийдвэрийг гаргасан болно.

ГУРАВ. ҮНДЭСЛЭЛ, ШИЙДВЭР

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3, 76 дугаар зүйлийн 76.1.2, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 60 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.4, 62.1.15, 62.1.16, 65 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12-р сарын 16-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг үндэслэн 2025 оны 02 сарын 03-ны өдрийн Богд банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар, Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5, 63.7, 63.8-д тус тус заасны дагуу хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ТӨРЛИЙГ ӨӨРЧИЛЖ ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 4.1 Компанийн тухай хуулийн, 76 дугаар зүйлийн 76.1.2, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 60 дугаар зүйл, 65 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гаргаж хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулж холбогдох шийдвэрийг гаргана.
- 4.2 “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.15, 62.1.16 дахь заалт, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь заалтын дагуу хаалттай хувьцаат компани болгох тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.
- 4.3 Банкны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3, 28.4-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийг Монголбанканд хүргүүлж холбогдох зөвшөөрлийг авна.
- 4.4 Монголбанк хаалттай хувьцаат компани болох асуудлыг зөвшөөрсөн нөхцөлд энэ талаар нийтэд мэдээнэ.
- 4.5 Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд Компанийн тухай хуулийн 24, 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу тухайн асуудлаар эсрэг саналтай байсан, хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигч хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүснэ.
- 4.6 Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6 дугаар бүлэг, Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 9 дүгээр бүлэгт тус тус заасны дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлж Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээс хасалт хийлгэнэ.
- 4.7 Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв болон Улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох баримт бичгийг бүрдүүлэн хүргүүлж компанийн дүрэм, гэрчилгээг шинэчлэн гаргуулна.

ТАВ. КОМПАНИЙН ТӨРЛИЙГ ӨӨРЧИЛЖ ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛСНООР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ҮҮСЭХ ЭРХ

Банк нь хаалттай хувьцаат компани болсноор “Компанийн тухай хууль”-ийн 3.8. дахь заалтын дагуу одоогийн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцаа нь үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бүртгэгдсэн хэвээр үлдэх бөгөөд хувьцааны арилжаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага /Монголын хөрөнгийн бирж/ -аас гадуур зах зээлд хаалттай хүрээнд арилжаалагдана.

Хаалттай хүрээнд хувьцааны арилжаа хийхдээ Санхүүгийн зохицуулах хорооны “Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагааны журам”-д заасны дагуу хувьцаа эзэмшигч нь худалдах, худалдан авах гэрээ, өв залгамжлах эрхийн гэрчилгээ, бэлэглэлийн гэрээ зэргийг үндэслэн хувьцааны өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх боломжтой.

Худалдах, худалдан авах гэрээний дагуу хувьцааны арилжааг хийхдээ худалдах, худалдан авах гэрээний нотариатаар гэрчлүүлсэн эх хувь, худалдах, худалдан авах гэрээний дагуу хийгдсэн төлбөр төлөгдсөн баримтын хуулбар эсхүл бэлнээр төлсөн бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, талуудын цахим үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг бүрдүүлэн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд ажлын 5 өдрийн дотор хүргүүлж хувьцааны арилжааг гүйцэтгэнэ.

Хаалттай хувьцаат компани болохтой холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн эсрэг саналтай байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч “Компанийн тухай хууль”-ийн 24, 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүсэх бөгөөд тус үйл ажиллагааны журмыг энэ төсөлд мөн нарийвчлан тусгасан байна.

ЗУРГАА. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХҮСЭЛТЭЭР КОМПАНИ ХУВЬЦААГАА ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАЖ АВАХ ЖУРАМ

- 6.1 Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь эргүүлж авах тухай шаардлагыг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргана.
- 6.2 Энэ журамд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг уг шаардах эрх үүссэн өдөр компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлд байсан мэдээллийг үндэслэн гаргана.
- 6.3 Цахим хэлбэрээр хүсэлт гаргах тохиолдолд Богд банкны stock@bogdbank.com цахим хаягт хүргүүлэх ба бичгээр хүсэлт гаргахдаа Бодь цамхаг, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж 3, Улаанбаатар 15160 хаягт орших Богд банкны төв оффист хүргүүлэх боломжтой бөгөөд хүсэлтэд дор дурдсан мэдээллийг заавал оруулсан байна. Үүнд:
- Овог, нэр
 - Оршин суугаа газрын хаяг
 - Холбоо барих утасны дугаар /2-оос дээш/
 - Регистрийн дугаар
 - Эргүүлэн худалдаж авахыг шаардаж буй хувьцааны тоо
- 6.4 Компани нь энэ журамд заасны дагуу ирүүлсэн хувьцаа эзэмшигчийн шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор эргүүлэн худалдаж авах эрхийн тухай мэдээлсэн мэдэгдэлд дурдсан зах зээлийн үнээр хувьцааг худалдан авах, эсхүл хувьцаа эзэмшигчийн хувьцааг эргүүлэн худалдаж авахаас татгалзсан үндэслэлээ хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.
- 6.5 Хувьцаа эзэмшигчдийн шаардлагын дагуу компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаа хэрэгжиж буйтай холбогдуулан компанийн хувьцааны арилжааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр түр зогсоож болно.
- 6.6 Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардаагүй хувьцаа эзэмшигчийн хувьцааг компанийг өөрчлөн байгуулах шийдвэрийн дагуу хөрвүүлж, тухайн хувьцаа эзэмшигч нь банкны хувьцаа эзэмшигч хэвээр үлдэнэ.

БОГД БАНК



БОГД БАНК

ХУВЬЦААТ КОМПАНИ



Богд цамхаг - 4-н давхар, Жигжиджавын гудамж,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар 15160, МОНГОЛ УЛС

Утас: +976 7577 1199
Факс: +976 11 328311
Вэб: www.bogdbank.com
И-мэйл: info@bogdbank.com